СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/212/-НА-СТА-ТШЗ


Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум

2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

“ЦЭСБ АУДИТ” ХХК-ийн аудитор: Ч.Цэрэннадмид

Утас: 9511 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт......3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан......4
2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан......6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан......8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан......9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан......11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан......13
3.Аудитын тайлан......14
3.1. Ерөнхий зүйл......13
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт......13
3.3 Санхүүгийн тайлангийн үзэл баримтлал......14
3.4. Материаллаг байдал......14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга......15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт......16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг......16
3.8 Аудитын гол асуудал......17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал......17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт......17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт......17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал......17
4.1 Залруулсан алдаа......18
4.2 Албан шаардлага, Зөвлөмж......18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл......20

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № СЭА-2022/212-НА-СТА-ТШЗ

танай ________________-ны № ________________-т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ШААМАР СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Д.ГАНЦЭЦЭГ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.



018020187

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭНХТУЯА

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ДЗМОУБ | Дэлхийн зөн, монгол, олон улсын байгууллага |
| БСШУЯ | Боловсрол соёл, шинжлэх ухааны яам |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| СЭА | Сэлэнгэ аймаг |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| БҮТЭЗ | Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчийн хурал |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **132,411,968.58** | **129,452,141.58** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | - |
| **33** | **АВЛАГА** | 62,600.00 | - |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 62,600.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **132,349,368.58** | **129,452,141.58** |
| **351** | **Түүхий эд материал** | **13,917,841.76** | **14,016,526.76** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 13,917,841.76 | 13,986,526.76 |
| 35130 | Эм боох материал | - | 30,000.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 773,410.00 | 52,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | **115,015,836.82** | **112,741,334.82** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 211,200.00 | 288,700.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 45,157,050.10 | 58,101,050.10 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 370,000.00 | 370,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 6,783,000.00 | 6,853,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 245,440.00 | 697,880.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 62,249,146.72 | 46,430,704.72 |
| 35600 | Мал амьтад | 2,642,280.00 | 2,642,280.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,264,535,094.75** | **2,263,075,214.54** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **2,264,535,094.75** | **2,263,075,214.54** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,030,135,596.00 | 2,030,135,596.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (100,868,692.16) | (152,346,000.08) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 14,562,500.00 | 14,562,500.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (14,562,500.00) | (606,770.83) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 299,301,616.71 | 255,845,662.65 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (138,845,384.84) | (60,760,678.00) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 119,908,502.61 | 117,550,600.12 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (51,606,759.03) | (53,035,751.38) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 56,905,487.61 | 65,007,018.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (21,540,680.98) | (9,004,953.63) |
| 39217 | Ном | 35,455,415.50 | 21,404,870.48 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **35,689,993.33** | **34,323,121.21** |
| 39301 | Програм хангамж | 6,001,027.55 | 6,001,027.55 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (575,034.22) | (1,941,906.34) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 30,264,000.00 | 30,264,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,396,947,063.33** | **2,392,527,356.12** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | - | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,396,947,063.33** | **2,392,527,356.02** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 756,321,843.72 | 756,321,843.72 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 30,921,175.15 | 26,501,467.84 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (149,444,910.04) | 30,921,175.15 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 180,366,085.19 | (4,419,707.31) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,609,704,044.46 | 1,609,704,044.46 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,396,947,063.33** | **2,392,527,356.02** |

## 2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,006,514,356.99** | **847,397,121.38** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **257,042,674.59** | **159,701,951.38** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **257,042,674.59** | **159,701,951.38** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 257,042,674.59 | 159,701,951.38 |
| | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө | 223,446,082.78 | 128,531,356.76 |
| | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 33,596,591.81 | 31,170,594.62 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **749,471,682.40** | **687,695,170.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **650,643,900.00** | **589,221,800.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 650,643,900.00 | 589,221,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 8,600,670.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 8,600,670.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **98,827,782.40** | **89,872,700.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 98,827,782.40 | 89,872,700.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **826,148,270.80** | **851,816,828.69** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **826,148,270.80** | **851,816,828.69** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **787,653,086.23** | **816,244,016.98** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **470,808,768.94** | **519,018,061.36** |
| 210101 | Үндсэн цалин | 444,778,735.94 | 368,387,440.36 |
| 210102 | Нэмэгдэл | - | 123,794,721.00 |
| 210104 | Урамшуулал | 26,030,033.00 | 26,835,900.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **60,022,286.09** | **57,084,073.92** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 37,840,046.65 | 39,870,725.21 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,151,245.44 | 5,232,078.55 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,821,080.00 | 3,230,010.19 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 655,446.00 | 796,141.17 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,554,468.00 | 7,955,118.80 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **85,755,182.40** | **86,848,400.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,165,099.40 | 5,250,500.00 |
| 210302 | Түлш, халаалт | 78,590,083.00 | 80,189,900.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 1,408,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **15,319,381.09** | **7,974,100.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,096,900.00 | 485,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,002,895.00 | 800,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 259,600.00 | 1,114,600.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 61,991.00 | 258,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 800,000.00 | 143,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,786,049.68 | 1,189,600.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 5,308,345.41 | 394,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210408 | Бараа материал акталсны зардал | 3,600.00 | 3,587,800.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **12,383,980.70** | **13,822,815.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 350,100.70 | 515,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 11,776,080.00 | 12,796,915.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 257,800.00 | 510,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **17,311,507.00** | **8,504,700.00** |
| | Багаж, техник, хэрэгсэл | 8,176,357.00 | 4,500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,135,150.00 | 4,004,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **186,900.00** | **193,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 186,900.00 | 193,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **37,415,535.00** | **1,605,200.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 36,839,535.00 | 957,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 576,000.00 | 648,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **88,449,545.01** | **121,193,666.70** |
| | Бараа, үйлчилгээний бусад зардал | 163,400.00 | |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,220,400.00 | 1,809,700.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 84,065,745.01 | 119,383,966.70 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **38,495,184.57** | **35,572,811.71** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **9,348,490.00** | **17,309,580.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 8,848,490.00 | 15,909,580.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 500,000.00 | 1,400,000.00 |
| | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **29,146,694.57** | **18,263,231.71** |
| | Төвлөрүүлэх шилжүүлэг | 29,146,694.57 | 18,263,231.71 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **180,366,086.19** | **(4,419,707.31)** |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **180,366,086.19** | **(4,419,707.31)** |

## 3.Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **749,471,682.40** | **687,695,170.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **749,471,682.40** | **687,695,170.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 650,643,900.00 | 589,221,800.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 650,643,900.00 | 589,221,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 8,600,670.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 8,600,670.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 98,827,782.40 | 89,872,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 98,827,782.40 | 89,872,700.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **727,653,882.40** | **681,122,170.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **727,653,882.40** | **681,122,170.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **689,147,787.83** | **645,549,358.29** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **471,112,499.59** | **473,036,895.37** |
| 210101 | Үндсэн цалин | 317,891,201.57 | 322,406,274.37 |
| 210102 | Нэмэгдэл | 113,497,598.43 | 123,794,721.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | |
| 210104 | Урамшуулал | 39,723,699.59 | 26,835,900.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **59,761,655.44** | **57,505,547.92** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 41,916,846.39 | 40,157,328.21 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,619,166.87 | 5,265,796.55 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,695,333.90 | 3,236,754.19 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 864,252.08 | 863,577.17 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,666,056.20 | 7,982,091.80 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **85,755,182.40** | **86,848,400.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,165,099.40 | 5,250,500.00 |
| 210302 | Түлш, халаалт | 78,590,083.00 | 80,189,900.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 1,408,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **5,317,900.00** | **4,270,800.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 276,500.00 | 699,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 800,000.00 | 800,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 259,600.00 | 1,114,600.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 250,300.00 | 33,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,135,900.00 | 433,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,595,600.00 | 1,189,600.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **11,879,900.00** | **13,822,815.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 217,500.00 | 515,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 10,698,600.00 | 12,796,915.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 963,800.00 | 510,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **15,630,300.00** | **4,107,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,608,600.00 | 102,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 14,021,700.00 | 4,004,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **186,900.00** | **193,000.00** |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 186,900.00 | 193,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **37,588,050.40** | **3,955,200.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 37,012,050.40 | 3,307,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 576,000.00 | 648,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,915,400.00 | 1,809,700.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 163,400.00 | |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,752,000.00 | 1,809,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **38,506,094.57** | **35,572,811.71** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | - | - |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | | |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | | |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 9,359,400.00 | 17,309,580.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 8,859,400.00 | 15,909,580.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 500,000.00 | 1,400,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | - |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **29,146,694.57** | **18,263,231.71** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 29,146,694.57 | 18,263,231.71 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **21,817,800.00** | **6,573,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 21,817,800.00 | 6,573,000.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 4. Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 756,321,843.72 | 1,609,704,044.46 | (149,444,910.04) | 2,216,580,978.14 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **756,321,843.72** | **1,609,704,044.46** | **(149,444,910.04)** | **2,216,580,978.14** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | 180,366,085.19 | 180,366,085.19 |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **756,321,843.72** | **1,609,704,044.46** | **180,366,085.19** | **2,546,391,973.37** |
| D01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **756,321,843.72** | **1,609,704,044.46** | **180,366,085.19** | **2,546,391,973.37** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **756,321,843.72** | **1,609,704,044.46** | **30,921,175.15** | **2,396,947,063.33** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | (4,419,707.31) | (4,419,707.31) |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **756,321,843.72** | **1,609,704,044.46** | **26,501,467.84** | **2,392,527,356.02** |

## 5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Дүн | Хувь |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 679,094,500.00 | 670,493,830.00 | 8,600,670.00 | 98.7 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 679,094,500.00 | 660,831,268.29 | 18,263,231.71 | 97.3 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **660,195,200.00** | **643,521,688.29** | 16,673,511.71 | 97.5 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **469,674,300.00** | **469,665,099.37** | 9,200.63 | 100.0 |
| 210101 | Үндсэн цалин | 315,544,500.00 | 322,406,274.37 | (6,861,774.37) | 102.2 |
| 210102 | Нэмэгдэл | 127,293,900.00 | 120,422,925.00 | 6,870,975.00 | 94.6 |
| 210104 | Урамшуулал | 26,835,900.00 | 26,835,900.00 | - | 100.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **62,426,400.00** | **57,084,073.92** | 5,342,326.08 | 91.4 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 43,368,300.00 | 39,870,725.21 | 3,497,574.79 | 91.9 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,764,500.00 | 5,232,078.55 | (467,578.55) | 109.8 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,811,600.00 | 3,230,010.19 | 581,589.81 | 84.7 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 952,900.00 | 796,141.17 | 156,758.83 | 83.5 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,529,100.00 | 7,955,118.80 | 1,573,981.20 | 83.5 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **86,848,400.00** | **86,848,400.00** | - | 100.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,250,500.00 | 5,250,500.00 | - | 100.0 |
| 210302 | Түлш, халаалт | 80,189,900.00 | 80,189,900.00 | - | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,408,000.00 | 1,408,000.00 | - | 100.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **3,988,700.00** | **3,988,700.00** | - | 100.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 485,600.00 | 485,600.00 | - | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 800,000.00 | 800,000.00 | - | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,114,600.00 | 1,114,600.00 | - | 100.0 |
| 210404 | Ном, хэвлэл | 258,600.00 | 258,600.00 | - | 100.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 140,300.00 | 140,300.00 | - | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд з | 1,189,600.00 | 1,189,600.00 | - | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | **25,144,800.00** | **13,822,815.00** | 11,321,985.00 | 55.0 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 515,400.00 | 515,400.00 | - | 100.0 |
| 210502 | Хоол, хүнс | 24,118,900.00 | 12,796,915.00 | 11,321,985.00 | 53.1 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 510,500.00 | 510,500.00 | - | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **8,504,700.00** | **8,504,700.00** | - | 100.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,500,000.00 | 4,500,000.00 | - | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 4,004,700.00 | 4,004,700.00 | - | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **193,000.00** | **193,000.00** | - | 100.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 193,000.00 | 193,000.00 | - | 100.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,605,200.00** | **1,605,200.00** | - | 100.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 957,200.00 | 957,200.00 | - | 100.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тог | 648,000.00 | 648,000.00 | - | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,809,700.00** | **1,809,700.00** | - | 100.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,809,700.00 | 1,809,700.00 | - | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **18,899,300.00** | **17,309,580.00** | 1,589,720.00 | 91.6 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **18,899,300.00** | **17,309,580.00** | 1,589,720.00 | 91.6 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 17,499,300.00 | 15,909,580.00 | 1,589,720.00 | 90.9 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,400,000.00 | 1,400,000.00 | - | 100.0 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 18,263,231.71 | (18,263,231.71) | |
| **1** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **589,221,800.00** | **589,221,800.00** | - | 100.0 |
| **131** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **589,221,800.00** | **589,221,800.00** | - | 100.0 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 589,221,800.00 | 589,221,800.00 | - | 100.0 |

## 6. Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **8,600,670.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **8,600,670.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 8,600,670.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | 3,371,796.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | - | **507,400.00** |
| 210401 | Бичиг хэрэг | - | 507,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | |
| 210404 | Ном, хэвлэл | - | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | **4,300,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 4,300,000.00 |
| 210602 | Тавилга | - | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | - |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | - |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | **8,600,670.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 8,600,670.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Ерөнхий боловсролын сургуулийн /*цаашид Шаамар сумын ЕБС гэх*/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн төлбөрийн цахим баримт, шилэн данстай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудиттай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ Аудит” ХХК-ийн захирал, аудитор Ч.Цэрэннадмид, ахлах аудитор Ш.Ганчимэг нар гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Шаамар сумын ЕБС-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “ЦЭСБ Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Шаамар сумын ЕБС *“Чанартай боловсрол, таатай орчин бүрдүүлэх зэрэг хандлагатай, чадварлаг баг хамт олон байхыг эрхэмлэнэ”* зорилгын хүрээнд *“Ажлын байрандаа хөгжих орчин нөхцөлийг сайжруулснаар багш нарын мэдлэг боловсрол, ур чадвар, заах арга зүйг дээшлүүлж, хамт олны дунд багш нарын зэрэг харилцаа хандлага, манлайллын чадварыг дээшлүүлэх”, “Хүүхэд нэг бүрийн сурч хөгжих, төлөвших эрүүл орчин нөхцөлийг стандартын дагуу бүрдүүлэхэд багш ажилчид эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх”* гэсэн зорилт тавин ажиллаж байна.

Тус сургууль үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Суурь болон бүрэн дунд боловсрол олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- БШУ-ны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 01 дугаар сарын 10-ны өдрийн А/05, А/10, 1 тоот хамтарсан тушаал "Шалгуур үзүүлэлт шинэчлэх тухай" ур чадвар

- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,
- "Нийгмийн даатгалын тухай хууль"-ийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 32 дугаар зүйлийн 1 дүгээр зүйл-д-НДШ-ийн хувь хэмжээнд өөрчлөлт орсон,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Тус сургуулийн мөрдөж байгаа аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар захирамжаар баталсан "Сэлэнгэ аймгийн орон нутгийн төсөвт байгууллагуудын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд тус сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

### 3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шаамар сумын ЕБС нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьаар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 838,032.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 8,380.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,866.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Шаамар сумын ЕБС-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,419.7 мянган төгрөгөөр буюу 0.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгийн засгийн газрын оролцоо дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

*Хүснэгт 1:* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Хувь хүнээс авах авлага | 62.6 | | (62.6) |
| Бараа материал | 132,349.4 | 129,452.1 | (2,897.3) |
| Үндсэн хөрөнгө | 2,264,535.1 | 2,263,075.2 | (1,459.8) |
| **Нийт хөрөнгө** | 2,396,947.1 | 2,392,527.4 | **(4,419.7)** |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 2,396,947.1 | 2,392,527.4 | (4,419.7) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 2,396,947.1 | 2,392,527.4 | **(4,419.7)** |

Тайлант онд хувь хүнээс авах авлага 62.6 мянган төгрөгийг бүрэн барагдуулж, үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 129,452.1 мянган төгрөг болж 2,897.3 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 40,111.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, БШУЯ-наас 14,556.8 мянган төгрөгийн биологийн лаборатори, ДЗМОУБ-ын Сэлэнгэ нэгдсэн хөтөлбөрөөс хүүхдийн тоглоомын талбайг тохижуулахад зориулан 12,577.8 мянган төгрөгийн барилгын материал, 672.4 мянган төгрөгийн хичээлийн хэрэглэгдэхүүн, сумын онцгой комисс болон сургуулийн багш, төгсөгчдөөс 3,363.6 мянган төгрөгийн тусгай зориулалтын бараа материал болон ариутгалын бодис үнэ төлбөргүйгээр хүлээн авч, 53,445.1 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулан, 20,734.2 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлснээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө үлдэгдэл */анхны өртгөөр/* 2,540,771.3 мянган төгрөг болж 51,762.8 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 6,573.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хандив тусламжаар 2,978.3 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр хүлээн авч, бараа материалын дансаас 20,734.2 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсан, сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 40 дүгээр тогтоолоор 82,048.3 мянган төгрөгийн хөрөнгийг акталснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,392,527.4 мянган төгрөг болж 4,419.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 179,851.5 мянган төгрөгөөр буюу 17.9 хувиар буурсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого буурснаас шалтгаалсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 834,943.9 мянган төгрөг болж 8,795.6 мянган төгрөгөөр өссөн нь бараа, ажил үйлчилгээний зардал өссөнөөс шалтгаалсан байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Шаамар сумын ЕБС сургууль нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 627,156.1 мянган төгрөгөөр тооцон төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 679,094.5 мянган төгрөгөөр баталж, 51,938.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн нь цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллыг өмнөх оны гүйцэтгэлээр төлөвлөснөөс шалтгаалжээ.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 679,094.5 мянган төгрөгийн төсөв батлалсныг тусгай зориулалтын шилжүүлгээс 589,221.8 мянга, орон нутгийн төсвөөс 89,872.7 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 589,221.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 89,872.7 мянган төгрөгийн нийт 679,094.5 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж урсгал үйл ажиллагаанд 660,831.3 мянган төгрөг зарцуулж, 18,263.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 660,831.3 мянган төгрөг буюу 98.7 хувьтай тайлагнагдсан нь цалин хөлс, нэмэгдэл урамшил 9.2 мянга, НДШ 5,342.3 мянга, хоол хүнсний зардал 11,322.0 мянга, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал /үдийн хоол/ -ын зардал 1,589.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд БШУЯ-наас Боловсролын чанарын шинэчлэл төслийн 4,300.0 мянган төгрөг, сумын Эрүүл мэндийн төвөөс /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэхэд ажилласан албан хаагчдын илүү цагийн хөлс 3,793.3 мянган төгрөг, аймгийн БСУГ-аас 507.4 мянган төгрөг нийт 8,600.7 мянган төгрөг төвлөрснийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт

**3.7.1** Боловсролын сайд болон Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2021 оны А/292 А/525 дугаар тушаалаар батлагдсан “Сургуулийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам”-ын дагуу цахим болон танхимын сургалтад шилжүүлсэн байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаа хоцроосон 24, оруулаагүй мэдээлэл 2 байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Шаамар сумын ЕБС тайлант оны үйл ажиллагаанд 679,094.5 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 660,831.3 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 2.3 хувиар хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: *“.....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”* гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллагын 2020 оны санхүүгийн тайлан,төсвийн гүйцэтгэлд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны А/60 дугаар тушаалаар “Итгэмжлэл” олгож, Зөрчилгүй санал дүгнэлт өгөгдсөн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан бараа материалын дансанд бүртгэгдсэн үндсэн хөрөнгүүдийг биетээр тулган баталгаажуулах боломжгүй байсан учир дараагийн аудитаар анхааран үзэх нь зүйтэй юм.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 100,924.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 20,734.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 80,189.9 төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өглөө.

### 4.1 Залруулсан алдаа

Бараа материалын дансанд бүртгэлтэй 20,734.2 мянган төгрөгийн 24 ширхэг хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгүүлж санхүүгийн тайланд залруулав.

### 4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав.

***1. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал:***

*1.1 Илрүүлэлт:* Шилэн дансанд мэдээлбэл зохих 24 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг мэдээлээгүй байна.

*1.2 Өгсөн зөвлөмж:* Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4 гэсэн заалтуудыг зөрчсөн тул холбогдох мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх.

***2. Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд***

*2.1 Илрүүлэлт:* Тайлант онд 80,189.9 мянган төгрөгийн худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

*2.2 Өгсөн зөвлөмж:* Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д "*Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй*" гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь "*Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ*" гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Шаамар сумын ЕБС | 3 | 100,924.1 | 1 | 20,734.2 | | | | | 2 | 80,189.9 |